



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 11 сарын 18 өдөр

Дугаар А/424

Улаанбаатар хот

“Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” арга
хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 2.1.1.14 (187) дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г нэгдүгээр, арга хэмжээний шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг мэргэжлийн арга зүйн нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газар (Б.Цэцэгсайхан)-т, Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн Урологи-Андрологийн төв (Д.Баян-Өндөр)-д тус тус даалгасугай.

3. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, биелэлтийг Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийн газарт жил бүрийн 6 дугаар сарын 01, 12 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг харьяа эрүүл мэндийн байгууллага, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4. Арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг жил бүрийн төсөвт тусгахыг Санхүү, эдийн засгийн бодлогын хэрэгжилтийн газарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар (Б.Янжмаа)-т даалгасугай.

САЙД



Ж.ЧИНБҮРЭН

141252354

**“ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД” АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2025-2028)**

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын хүн амын төрөлтөөс тооцсон дундаж наслалт 2024 онд улсын хэмжээнд 71.77 болж, сүүлийн 10 жилийн дунджаас 1, өмнөх оноос 0.3 жилээр тус тус нэмэгдсэн байна. Хүйсээр харуулбал, эмэгтэйчүүдийн дундаж наслалт 77.1, эрэгтэйчүүдийнх 67.9 жил байгаа бөгөөд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дундаж наслалтын зөрөө 9.2 жил байгаа нь дэлхийн дундаж (3-6 жил)-аас өндөр үзүүлэлт юм.

Монгол Улсад жилд дунджаар 18.1 мянга орчим хүн нас барж байгаагийн 63.5% нь эрэгтэйчүүд бөгөөд шалтгаанаар нь авч үзвэл зүрх судасны тогтолцооны өвчин 31.3%, осол гэмтэл, гадны шалтгаан 23.4%, хавдар 23.0% зонхилж байна. Нас баралтын тэргүүлэх шалтгаан, 10,000 хүн амд зүрх судасны өвчин эрэгтэйд 21.32, эмэгтэйд 12.62, Гэмтэл, хордлого, гадны шалтгаан эрэгтэйд 16.00, эмэгтэйд 3.84, хорт хавдар эрэгтэйд 15.70, эмэгтэйд 11.04 байгаа нь эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйчүүдээс 1.68-4.16 дахин их байна.

Хүн амын нас баралтын тэргүүлэх шалтгаанаар авч үзэхэд нас баралтын түвшин эрэгтэйчүүдэд их байгаа боловч тэдгээр шалтгааны улмаас амбулаторид үзүүлэх байдал эрэгтэйчүүдэд бага байна. Амбулаторт бүртгэгдсэн нийт өвчлөлийн байдлыг харахад эрэгтэйчүүдэд амбулаторийн үзлэг эмэгтэйчүүдтэй харьцуулахад 1.6 дахин бага байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт нь Монгол хүний нас баралтын 3 дахь шалтгаан болсоор байгаа бөгөөд 2024 оны байдлаар нийт нас баралтын 18.6 хувийг эзэлж байна. Зам тээврийн осол, амиа хорлолт, үйлдвэрлэлийн осол, бусдад хорлогдсон, бусад осол, тодорхой бус гэсэн шалтгаануудаар эрэгтэйчүүдийн нас баралт эмэгтэйгээс харьцангуй өндөр байна.

Улсын хэмжээнд осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 10,000 хүн амд 2024 оны статистик тоо баримтаар зам тээврийн осолд эрэгтэй 3.5, эмэгтэй 1.9, амиа хорлолт эрэгтэй 4.0, эмэгтэй 1.0, бусдад хорлогдсон эрэгтэй 1.7, эмэгтэй 0.6, үйлдвэрийн осол эрэгтэй 0.2, эмэгтэй 0.0 байна.

Архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, эрүүл бус хооллолт зэрэг амьдралын буруу хэв маяг, дадал, зуршил эрэгтэйчүүдэд их байгаагаас халдварт бус өвчинд өртөмтгий байна. 2019 оны “Халдварт бус өвчин, осол гэмтлийн шалтгаан эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын шаталсан IV” судалгаагаар Монгол Улсын хүн амын 24.2%, үүнээс эрэгтэйчүүдийн 43.7% нь тамхи татдаг, эрэгтэйчүүдийн дунд согтууруулах ундааны хэрэглээ 44.9% буюу эмэгтэйчүүдээс 1.8 дахин их байна. Мөн эрэгтэйчүүдийн 48.3% таргалалттай, жимс ногооны хэрэглээ эмэгтэйчүүдтэй харьцуулахад бага байдаг байна.

Монгол Улсын Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн томоохон арга хэмжээ болох Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоог 2022 оны 05 дугаар сарын 01-нд эхлүүлж, 2025 оны 10 дүгээр сарын байдлаар улсын хэмжээнд хамрагдвал

зохих хүн амын 51.1% буюу 1.727.428 иргэнийг хамруулаад байна. Үзлэгт хамрагдсан иргэдийн 747.390 буюу 43.3% нь эрэгтэйчүүд, 980.038 буюу 56.7% нь эмэгтэйчүүд байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар “Эрүүл, чийрэг эр хүн” арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд 4 зорилтын хүрээнд нийт 46 үйл ажиллагааг төлөвлөн баталж хэрэгжүүлсэн. Арга хэмжээний төлөвлөгөөний зорилго нь эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, дундаж наслалтыг нэмэгдүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд оршиж байсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх 46 арга хэмжээний биелэлт 49.6%-тай байсан.

Дээр дурьдсан өвчлөл, эндэгдэл, зан үйлийн талаарх нотолгоог харгалзан “Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөө (2025-2028)-г боловсруулахдаа Монгол Улсын урт болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд болон олон улсад эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр гарсан бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан боловсруулж өмнөх “Эрүүл, чийрэг эр хүн” арга хэмжээний 2021-2024 онд хэрэгжүүлсэн төлөвлөгөөний биелэлт хангалтгүй үнэлэгдсэн заалтуудаас тусгасан болно.

Хоёр. Арга хэмжээний зорилго, зорилт

2.1. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих, тэдэнд хүрэх тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан, дундаж наслалтыг нэмэгдүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

2.2. Дээрх зорилгын хүрээнд дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ:

2.2.1. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж буй бодлого, эрхзүйн орчинг боловсронгуй болгох;

2.2.2. Бүх шатны бодлого боловсруулагчид, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчид, байгууллага хамт олон, гэр бүл болон эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг эрчимжүүлэх замаар эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн эрсдэлт зан үйлийг өөрчлөх;

2.2.3. Эрэгтэйчүүдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах;

2.2.4. Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын ач холбогдолыг таниулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх.

Гурав. Арга хэмжээг хэрэгжүүлэх зарчим

3.1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална:

3.1.1. Эрэгтэйчүүдэд үзүүлэх нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх;

3.1.2. Эрэгтэйчүүдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх;

3.1.2. Үйлчлүүлэгчийн нэр төрийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхахгүй байх;

3.1.3 Оролцогч талуудын оролцоо, хамтын ажиллагааг хангаж, нотолгоонд тулгуурлах;

Дөрөв. Арга хэмжээ хэрэгжүүлэх хугацаа, зохион байгуулалт

4.1. Арга хэмжээний төлөвлөгөөг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

4.2. Арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар орон нутагтаа нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, шаардагдах зардлыг орон нутгийн төсөв, хамтын ажиллагаатай улс орон болон олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан, төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлж, үр дүнг тайлагнана.

4.4. Эрүүл мэндийн болон бусад салбарын төрийн болон төрийн бус байгууллагууд уг арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж ажиллана.

Тав. Арга хэмжээний санхүүжилт

5.1. Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;

5.1.3. гадаадын зээл буцалтгүй тусламж;

5.1.4. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

---oOo---

“ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД” (2025-2028) АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Суурь түвшин	Хүрэх түвшин				Оролцогч талууд		Шаардагдах төсөв (сая.төг)					Санхүүгийн эх үүсвэр		
		2024 он	2025 он	2026 он	2027 он	2028 он	Зохицуулах/ Хэрэгжүүлэх	Хамтрах	2025	2026	2027	2028	Нийт	Уусвар		
Зорилго: Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих замаар эрүүл урт насалтыг нэмэгдүүлэх																
Зорилт: 1. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих бодлого эрхзүй, нийгмийн олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, нотолгоонд суурилсан тандалт, судалгааг бэхжүүлэх 2. Эрэгтэйчүүдийн дундах эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах 3. Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх 4. Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдалтын ач холбогдолыг таниулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлэх																
1	Зорилт 1. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих бодлого эрхзүй, нийгмийн олон талт хамтын ажиллагааг өргөжүүлэх, нотолгоонд суурилсан тандалт, судалгааг бэхжүүлэх															
1.1	Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавхийг салбар дундын оролцоотой бэхжүүлэх	Эрэгтэйчүүдийг дэмжих төв - 1	–	–	–	Салбар дундын хамтарсан уулзалт зохион байгуулсан байна	Эрэгтэйчүүдийг дэмжих төвийг орон нутагт 1 бүсэд байгуулсан байна	Дэмжих төвүүдийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж, үр дүнг тооцсон байна	ЭМЯ ГЕХНХЯ	АНЗДТГ, Холбогдох яам, агентлагууд ТББ-ууд	20.0	20.0	120.0	20.0	180.0	Улсын төсөв, ОУБ, ЭМДС
1.2	"Урологи, андрологийн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам" боловсруулж, батлуулах	–	Журмын төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулсан байна	Эрүүл мэндийн сайдын тушаалаар журам батлагдсан байна	ЭМБ-уудад хэрэгжүүлсэн байна	ЭМБ-уудад хэрэгжүүлсэн байна	Журмын хэрэгжилтэд үнэлгээ хийгдсэн байна	–	ЭМЯ-ны ЭТБХГ, НЭМТБХГ	УНТЭ-УАТ МСЗ	–	10.0	20.0	30.0	–	–
1.3	"Түрүү булчирхайн хоргүй хавдрын оношилгоо, эмчилгээ" MNS6100:2010 стандартыг шинэчлэх	2010 онд батлагдсан стандарт	Стандарт боловсруулах ажлын хэсэг байгуулсан байна	Стандартын төслийг хэлэлцүүлж, батлуулсан байна	ЭМБ-уудад мөрдүүлсэн байна	ЭМБ-уудад мөрдүүлсэн байна	Стандартын мөрдөлтийг үнэлсэн байна	–	ЭМЯ-ны ЭТБХГ, НЭМТБХГ	УНТЭ-УАТ ХСҮТ МСЗ	–	25.0	5.0	10.0	40.0	ОУБ
1.4	"Бөөрний чулууны оношлогоо, эмчилгээ" MNS6099:2010 стандартыг шинэчлэх	2010 онд батлагдсан стандарт	Стандарт боловсруулах ажлын хэсэг байгуулсан байна	Стандартын төслийг хэлэлцүүлж, батлуулсан байна	ЭМБ-уудад мөрдүүлсэн байна	ЭМБ-уудад мөрдүүлсэн байна	Стандартын мөрдөлтийг үнэлсэн байна	–	ЭМЯ-ны ЭТБХГ, НЭМТБХГ	УНТЭ-УАТ МСЗ	–	25.0	5.0	10.0	40.0	ОУБ
1.5	Онко урологийн оношилгоо, эмчилгээний удирдамж боловсруулах	–	Удирдамж боловсруулах ажлын хэсэг байгуулсан байна	Эрүүл мэндийн сайдын тушаалаар удирдамж батлагдсан байна	ЭМБ-уудад хэрэгжүүлсэн байна	ЭМБ-уудад хэрэгжүүлсэн байна	–	–	ЭМЯ-ны ЭТБХГ, НЭМТБХГ	ХСҮТ МСЗ	–	10.0	30.0	40.0	–	–
1.6	Эрэгтэйчүүд, хөвгүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгчдийн ажлын байрны тодорхойлж батлуулах	–	–	Ажлын байрны тодорхойлогч батлуулсан байна	Үйл ажиллагаанд мөрдлөг болгосон байна	–	–	–	ЭМЯ-ны БТГ, НЭМТБХГ	УНТЭ-УАТ МСЗ	–	10.0	30.0	40.0	–	–

Эрүүл мэндийн сайдын 2025 оны ... дугаар сарын 18 өдрийн ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

1.7	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээрх нэн шаардлагатай судалгаа, эрдэм шинжилгээний тэргүүлэх чиглэлийг тогтоож судалгааны ажил хийх	-	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн чиглэлээр хийх судалгааны тэргүүлэх чиглэлийг салбарын судалгаа, шинжилгээний тэргүүлэх чиглэлд оруулж баталгаажуулсан байна.	Судалгааны ажлын санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэж, сонгон шалгаруулалт зарласан байна.	Судалгааны ажлууд хийгдэж тайлан гарсан байна	Судалгааны ажлууд хийгдэж тайлан гарсан байна	ЭМЯ-ны БТГ, ЭТЕХГ, ЭМХТ, УНТЗ-УАТ, НЭМҮТ	МСЗ, АШУУИС Мэргэжлийн нийгэмлэг холбоод, хувийн хэвшлийн ЭМБ	400.0	800.0	800.0	2000.0	ШУТС, ЭМДС, ОУБ	
2	Зорилт 2. Эрэгтэйчүүдийн дундах эрүүл амьдралын хэв маягийг дэмжих, эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах													
2.1	Өсвөр насны эрэгтэй хүүхдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлээр контент хийн, түгээх	-	Контентын агуулгыг гаргасан байна	10 контентийг хийж түгээсэн байх	15 контентийг хийж түгээсэн байх	15 контентийг хийж түгээсэн байх	ЭМЯ НЭМҮТ	БЕГ ЭХЭМҮТ ЭНЭҮТ-2	30.0	50.0	70.0	20.0	170.0	ЭМДС, ОУБ
2.2	Эрэгтэйчүүдийн дунд осол, гэмтлээс сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг олон нийтийн цахим сүлжээгээр тогтмол хийх	ЗГҮАХ 2021-2024	Эрэгтэйчүүдэд зориулсан цуврал 2 контент хийсэн байна	Эрэгтэйчүүдэд зориулсан цуврал 2 контент хийсэн байна	Эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 контент хийсэн байна	Эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 контент хийсэн байна	ЭМЯ НЭМҮТ	БЕГ ЭХЭМҮТ ГССҮТ СЭМҮТ	30.0	50.0	50.0	50.0	180.0	Эрүүл мэндийг дэмжих сан
2.3	Өсвөр насныхны дунд сэтгэцийн эрүүл мэнд, дэлгэцийн зохистой хэрэглээ болон мансууруулах сэтгэц нөлөөт бодисын хэрэглээнээс татгалзах, донтогтоос сэргийлэх зорилгоор зөвлөгөө өгөх, эрт илрүүлэх, эмчлэх, хянах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	-	Эмч, мэргэжилтэн нарыг сургах сургалтын хөтөлбөр боловсруулсан байна	Өсвөр үе, сургуулийн эмч, сэтгэлзүйч, нийгмийн ажилтан нар дунд 2 удаагийн сургалт зохион байгуулсан байна	3 удаагийн сургалт зохион байгуулсан байна	Дэмжлэгт хяналт хийж, зөвлөмж гарсан байна	СЭМҮТ, НЭМҮТ, ЭМХТ, Аймаг, нийслэлийн ЭМГ	Бусад ЭМБ, Бусад салбар, Хэвлэл мэдээллийн байгууллага	25.0	50.0	80.0	20.0	175.0	ЭМДС, Орон нутгийн төсөв, Байгууллагын төсөв НҮБХС, НҮБХАС, ДЭМБ
2.4	Өсвөр эрэгтэй насныхны зохистой хооллолт, шим тэжээлийн талаар интерактив сургалтын модуль боловсруулан түгээж, сургалт зохион байгуулах	-	Сургалтын модуль боловсруулна	Интерактив сургалтын модуль боловсруулан 30 эмч, мэргэжилтэн нарыг сургасан байна.	Үе тэнгийн сургалтыг өсвөр үеийнхэнд 2 удаа зохион байгуулсан байна	Үе тэнгийн сургалтыг өсвөр үеийнхэнд 1 удаа зохион байгуулсан байна	ЭМЯ-ны НЭМБХГ, НЭМҮТ, ЭХЭМҮТ, ЭМХТ	Аймаг нийслэлийн ЭМГ, БЕГ, Боловсролын байгууллагууд ОУБ	25.0	50.0	50.0	25.0	150.0	ЭМДС, Байгууллагын төсөв, ОУБ
2.5	Жолооч нарын эрүүл мэндэд онцгойлон анхаарч ажилласан байгууллагыг олон нийтэд мэдээлэх, сурталчлах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх ажлыг зохион байгуулах	-	Удирдамжны төсөл боловсруулсан байна	Сайн туршлагын удирдамж батлагдсан байна	Сайн туршлагыг олон нийтэд сурталчлан таниулсан 2 удаагийн сургалт хийсэн байна	Сайн туршлагыг олон нийтэд сурталчлан таниулсан 2 удаагийн сургалт хийсэн байна	ЭМЯ ЗТЯ ЦЕГ	НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ, АНЭМГ, ЖҮХ	10.0	20.0	20.0	50.0	Улсын төсөв	
2.6	Малчин эрэгтэйчүүдэд чиглэсэн амьдралын зөв дадал бий болгох, эрүүл урт наслах зан үйлийг хэвшил болгох зорилтот аян өрнүүлэх	-	Аян зохион байгуулах талаар холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулсан байна	Аян зохион байгуулах удирдамж батлуулан, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна	Аянг тогтмол зохион байгуулж манлайлсан байгууллагуудыг урамшуулсан байна	Аяны үр дүнг тооцож хэлэлцүүлж тайлан бичсэн байна	ЭМЯ ХХААХҮЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	25.0	50.0	50.0	125.0	Улсын төсөв	
2.7	Уул уурхай, дэд бүтцийн салбарт ажилладаг эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах	-	-	Сургалтын удирдамж, хөтөлбөр батлуулсан байна	10 байгууллагад сургалт зохион байгуулсан байна	10 байгууллагад сургалт зохион байгуулсан байна	ЭМЯ УУХҮЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ		5.0	80.0	80.0	ОУБ	

2.8	ҮБХИС, ДХИС-ийн сургалтын хөтөлбөрт эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар багц цагийн сургалтын хөтөлбөр оруулж, төсөгчдөөр дамжуулан хугацаат цэргийн алба хаагчдад эрүүл мэндийн боловсрол олгох	ДХИС-ийн сургалтын хөтөлбөрт орсон	ҮБХИС-ийн сургалтын хөтөлбөрт оруулахаар санал хүргүүлсэн байна	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн талаар багц цагийн сургалтын агуулгад оруулсан байна	Хугацаат цэргийн алба хаагчдад эрүүл мэндийн боловсрол олгох сургалтад 100 хүн хамруулсан байна	Сургалтын үр дүнг тооцож тайлан бичсэн байна	ЭМЯ БХЯ ХЗДХЯ	БШУЯ СЭМУТ ЖУХ	10.0	20.0	20.0	50.0	–
2.9	Эрэгтэйчүүдийн дунд сэтгэцийн эрүүл мэндийн талаарх ойлголт, мэдлэг түгээх, стрессийг даван туулах, амиа өгүүтгээс урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт, зөвлөгөө өгөх	ЭЭХДНЗБ 2024-2027	–	Үйл ажиллагаа явуулах талаар удирдаж гарган батлуулж, холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна	Сургалтыг 3 байгууллагад зохион байгуулсан байна	Сургалтыг 3 байгууллагад зохион байгуулсан байна	ЭМЯ СЭМУТ	ГБХНХЯ ТББ	10.0	25.0	25.0	60.0	Улсын төсөв
2.1	Эрүүл зан үйл, амьдралын зөв дадал хэвшлийг төлөвшүүлэх, архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээнээс татгалзахыг уриалсан тайз, дэлгэцийн уран бүтээл захиалж хийлгэх, дэмжлэг үзүүлэх	ЭЭХДНЗБ 2024-2027	–	Уран бүтээл гарсан байна	Уран бүтээл гарсан байна	Уран бүтээл гарсан байна	ССАЖЗЯ	ЭМЯ	50.0	50.0	25.0	125.0	Улсын төсөв
2.11	Эрэгтэйчүүдийн физиологи, бие бялдрын хувьд эрүүл, илүүдэл жингүй байх уриалга, арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах	ЭЭХДНЗБ 2024-2027	Уриалга болон лого гаргасан байна	Үйл ажиллагаа явуулах талаар удирдаж гарган холбогдох байгууллагуудад хүргүүлсэн байна	Арга хэмжээ зохион байгуулсан байна	Үр дүнг үнэлж тайлан бичсэн байна	ЭМЯ НЭМУТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	25.0	50.0	50.0	125.0	Улсын төсөв
2.12	Зурх судас, артерийн даралт ихсэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 20 наснаас дээш насны эрэгтэйчүүдийг артерийн даралтаа хэмжих, хянахад хэвшүүлэх, "80/120" богино хугацааны нөлөөллийн аяныг тогтмол зохион байгуулах	ЭЭХДНЗБ 2024-2027	Аян зохион байгуулах талаар холбогдох байгууллагуудтай уулзалт зохион байгуулсан байна	Аймаг, дүүрэгт зохион байгуулагдах урьдчилан сэргийлэх мэдлэг олгох үйл ажиллагаа аж ахуйн нэгж, иргэдийн хамруулсан байна	Аймаг, дүүрэгт зохион байгуулагдах урьдчилан сэргийлэх мэдлэг олгох үйл ажиллагаа аж ахуйн нэгж, иргэдийн хамруулсан байна	Үр дүнг үнэлсэн байна	ЭМЯ НЭМУТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	50.0	50.0	5.0	155.0	Улсын төсөв

Зорилт 3. Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх

3													
3.1	Өсвөр үеийн эмч, сургуулийн эмч, нийтийн ажилтан, сэтгэл зүйч нарыг эрэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх үр чадварт сургах	–	Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна	Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө батлуулан, гарын авлага гаргасан байна	Сургалтын байгууллагын эмч, ажилтнуудад сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна	Сургалтын байгууллагын эмч, ажилтнуудад сургалтыг 2 удаа зохион байгуулсан байна	ЭМЯ НЭМУТ, СЭМУТ	БЕГ АНЭМГ	30.0	50.0	50.0	180.0	Эрүүл мэндийг дэмжих сан
3.2	Хөгжлийн бэрхшээлтэй хөвгүүд, эрэгтэйчүүдэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүргэхэд хүний нөөцийг чадавхижуулах	–	Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна	Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө батлуулан, гарын авлага гаргасан байна	Сургалтад эмч, мэргэжилтнүүдийн сургаж бэлтгэсэн байна	Тусгай хэрэгцээт сургуулийн суралцагчдад сургалт зохион байгуулсан байна	ЭМЯ НЭМУТ	ГБХНХЯ ЭМХТ АНЭМГ	15.0	80.0	80.0	175.0	Улсын төсөв
3.3	Цэргийн нэгтгэл, анги, байгууллагын эмч, мэргэжилтэн эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх, зөвлөгөө өгөх үр чадварт сургах	–	Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна	Сургалтын хөтөлбөр төлөвлөгөө батлуулан, гарын авлага гаргасан байна	Сургалтад эмч, мэргэжилтнүүдийн сургаж бэлтгэсэн байна	Сургалтад зорилтот бүлгийн иргэдийн хамруулсан байна	БХЯ, ЭМЯ-ны ЭТБХГ, НЭМТБХГ	Хөндсэрийн үндэсний хороо НЭМУТ АНЭМГ	15.0	80.0	80.0	175.0	Улсын төсөв

3.4	Бөөрний дээд замын чулуу бутлах дурагийн мсэ заслыг орон нутагт нутагшуулах	-	6 аймагт нутагшуулсан байна	1 аймагт нутагшуулсан байна	2 аймагт нутагшуулсан байна	3 аймагт нутагшуулсан байна	ЭМЯ-ны ЭТБХГ, УНТЭ-УАТ	АЭМГ-ууд МСЗ	800.0	200.0	200.0	200.0	1400.0	Улсын төсөв
3.5	Эрэгтэйчүүдийн үйргүүдийн чиглэлээр тусламж, үйлчилгээг өргөжүүлэх	2 эмнэлэг	Эрэгтэйчүүдийн үргүүдийн тусламж, үйлчилгээнд үнэлгээг хийсэн байна.	Нийслэлийн 2-3 эмнэлэгт үргүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болсон байна.	Орон нутагт 2 эмнэлэгт үргүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болсон байна	Орон нутагт 2 эмнэлэгт үргүүдийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг болсон байна	ЭМЯ ЭХЭМҮТ УНТЭ-УАТ	АНЭМГ МСЗ	50.0	500.0	500.0	500.0	1550.0	Улсын төсөв
3.6	Эрэгтэйчүүдийн кабинетийн үйл ажиллагааг өргөжүүлэх, тогтмолжуулах	ЭМ-ийн ЖСЗ 2025	-	Стандартын дагуу тохижуулсан 2 кабинет	Стандартын дагуу тохижуулсан 2 кабинет	Стандартын дагуу тохижуулсан 2 кабинет	ЭМЯ-ны ЭТБХГ, НЭМТБХГ	Аймаг, нийслэлийн ЗДТГ Жендэрийн үндэсний хороо	800.0	800.0	800.0	800.0	2400.0	-
3.7	Улсын хэмжээнд Урологи Андрологийн лавлагаа тусламж үзүүлдэг эмч нараас өндөр хөгжилтэй орнуудад богино хугацааны Андрологийн сургалтад хамруулах	ЗГҮАХ 2021-2024	Хэрэгцээ, шаардлагын судалгаа гаргасан байна	Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна	2 эмчийг сургасан байна	2 эмчийг сургасан байна	ЭМХТ	УНТЭ-УАТ МСЗ	20.0	20.0	50.0	50.0	140.0	
3.8	Андрологи, урологийн чиглэлээр хүний нөөцийг мэргэшүүлэх, сургаж бэлтгэх	ЭМ-ийн ЖСЗ 2025	Хүний нөөцийг сургаж эхэлсэн байна	5 эмчийг сургасан байна	5 эмчийг сургасан байна	5 эмчийг сургасан байна	ЭМЯ-ны ЭТБХГ, НЭМТБХГ ЭМХТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ ЖҮХ	125.0	125.0	125.0	125.0	375.0	-
4	Зорилт 4. Эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах ач холбогдолтой таниулахад чиглэсэн арга хэмжээг зохион байгуулж, эрт илрүүлэг, үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамрагдахыг нэмэгдүүлэх													
4.1	Эрэгтэйчүүдэд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийн ач холбогдол болон үзлэг, шинжилгээ, оношилгоонд хэрхэн хамрагдах талаарх заавар зөвлөмжийг видео, шторж, постер хэлбэрээр бэлтгэн цахим хуудас, пэйж хуудсаар түгээх	2024 оны төсөл	Эрэгтэйчүүдэд зориулсан контент хийсэн байна	МСС цувралаар тогтмол зохион байгуулсан байна	Зорилтот бүлэгт тохирсон мэдээлэл, сурталчилгаа хийгдсэн байна	Эрэгтэйчүүдийн эрдэлт зан үйл буурсан байна	ЭМЯ НЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд, Хэвлэл мэдээллийн байгууллагууд	50.0	50.0	50.0	30.0	180.0	Эрүүл мэндийг дэмжих сан
4.2	Малчны хотонд хүрч, малчин эрэгтэйчүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах	ЭЭХДНЗБ 2024-2027	-	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан 500 малчин эрэгтэйчүүдийг хамруулсан байна	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан 500 малчин эрэгтэйчүүдийг хамруулсан байна	Эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан 500 малчин эрэгтэйчүүдийг хамруулсан байна	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ	800.0	800.0	800.0	800.0	2400.0	ЭМДЕГ
4.3	Цэргийн насны эрэгтэйчүүдийн бүс нутагт илэрсэн эрүүл мэндийн асуудалд дүн шинжилгээ хийн, түүнд чиглэсэн ухуула нөлөөллийн ажил зохион байгуулах	2024 оны төсөл	-	Салбар хоорондын уулзалт хийсэн байна	Дүн шинжилгээ хийгдэж, түүнд чиглэсэн ухуула нөлөөллийн ажил зохион байгуулсан байна	Ухуула нөлөөллийн ажилын үр дүнг тооцож тайлан бичсэн байна	БХЯ ЭМЯ ХЗДХЯ	НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ ЖҮХ	50.0	120.0	120.0	120.0	290.0	Улсын төсөв ОУБ-ууд
4.4	Эрэгтэйчүүд олноор ажиллаж, суралцдаг салбарын ажилтан, албан хаагч, цэрэг, сонгогчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдахыг нэмэгдүүлэх чиглэлээр аян зохион байгуулах	2024 оны төсөл	Салбар хоорондын уулзалт, хэлэлцүүлэг хийсэн байна	Салбар хооронд аян зохион байгуулах аяны удирдамж батлаж хүргүүлсэн байна.	Аяныг тогтмол зохион байгуулж, манайлсан байгууллага хамт олныг урамшуулж, олон нийтэд сурталчилсан байна.	Аяны үр дүнг тооцож, тайлан бичсэн байна	БХЯ ХЗДХЯ УУХУЯ ЗТХЯ	ЭМЯ НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ ЖҮХ	20.0	20.0	80.0	80.0	200.0	Улсын төсөв

4.5	Цэрэг, цагдаагийн сургалтын хөтөлбөрт анхны яаралтай тусламж үзүүлэх сургалтын агуулгыг тусгах	Идэр чийрэг Монгол цэрэг 2025	Сургалтын хөтөлбөр боловсруулсан байна	Сургалтад цэрэг, цагдаагийн албан хаагчдыг хамруулсан байна	Сургалтад цэрэг, цагдаагийн албан хаагчдыг хамруулсан байна	Сургалтад цэрэг, цагдаагийн албан хаагчдыг хамруулсан байна	ЭМЯ БХЯ ХЗДХЯ	БШУЯ ЭМХТ ЖҮХ	20.0	100.0	100.0	100.0	100.0	320.0	-
4.6	Төрийн цэргийн болон тусгай чиг үүрэг бүхий байгууллага, уул уурхай, барилга, зам тээврийн зэрэг үйл ажиллагааны онцлогоос хамааран эрэгтэйчүүд олноор ажилладаг байгууллагын эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах	ЭЭХДНЗБ 2024-2027	Салбар бүрээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна	Салбар бүрээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна	Салбар бүрээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна	Салбар бүрээр эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан байна	ЭМЯ, ГЕХНХЯ	Холбогдох яам, агентлагууд	800.0	800.0	800.0	800.0	800.0	3200.0	ЭМДЕГ
4.7	Мэргэжлээс шалтгаалсан өвчнийг илрүүлэх эрүүл мэндийн хугацаат үзлэгийг уурхайд газрын дор хортой, хүнд, халуун нөхцөлд ажилладаг, тээврийн жолооч нарт жил тутамд хийх	10000	10500	11000	11500	12000	ЭМЯ ГЕХНХЯ	Холбогдох яам, агентлагууд	800.0	800.0	800.0	800.0	800.0	3200.0	ЭМДЕГ

Арга хэмжээний төлөвлөгөө 4 Зорилтын хүрээнд 33 арга хэмжээ төлөвлөж, төсөв нь 20.0 тэрбум төгрөг

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 14 сарын 18-дрийн 4 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

“ЭРЭГТЭЙЧҮҮДИЙН ЭРҮҮЛ МЭНД” (2025-2028) АРГА ХЭМЖЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

“Эрэгтэйчүүдийн эрүүл мэнд” арга хэмжээний үр нөлөө, үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр дүгнэх бөгөөд 2024 оны статистик, мэдээллийг суурь үзүүлэлт болгон ашигласан болно.

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (оноор)				Хариуцах байгууллага
			2024	2025	2026	2027	2028	
Өвчлөлийн үзүүлэлт (эрэгтэйчүүдэд)								
2	Зүрх судасны тогтолцооны өвчөлийн түвшин /10000 хүн амд/**	Тохиолдол	1003.6	983.5	963.2	943.5	924	- Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
	Гэмтэл, хордлого ба бусад гадны шалтгаант өвчөлийн түвшин /10000 хүн амд/**	Тохиолдол	971.4	952.6	933.7	915.1	896.5	-Эрүүл мэндийн хөгжлийн төв
Нас баралтын үзүүлэлт (эрэгтэйчүүдэд)								
3	Зүрхний ишеми өвчнөөс шалтгаалсан нас баралтын түвшин /25 наснаас дээш 100000 хүн амд/**	Тохиолдол	168.6	164.3	159.9	155.7	151.4	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

	Уушигны хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин /100000 хүн амд/**	Тохиолдол	43.6	42.5	41.4	40.3	39.2	- Эрүүл мэндийн хөгжлийн төв
	Осол гэмтэл, гадны шалтгааны улмаас нас барсан тохиолдол /100000 хүн амд/**	Тохиолдол	160.0	156	151.9	147.9	144	
	Тархинд цус харвалт өвчнөөс шалтгаалсан нас баралтын түвшин /100000 хүн амд/**	Тохиолдол	122.9	120	117.1	114.3	111.5	
	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин /100000 хүн амд/**	Тохиолдол	27.3	26.6	26	25.3	24.6	

Эмнэлгийн тусламж үйлчилгээний үзүүлэлт

4	Эрт илрүүлэг үзлэгт эрэгтэйчүүдийн хамрагдсан хувь ***	Хувь	42.2	45.4	49.0	52.1	55.0	- Улсын нэгдсэн төв эмнэлгийн Урологи-Андрологийн Төв - Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв
	Эрэгтэйчүүдийн эмчийн (урологи, андрологи) тоо	Тоо (Урологи)	57	60	70	80	90	
		Тоо (Андрологи)	15	18	23	30	40	
	Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинетын (урологи, андрологи) тоо	Тоо	12	14	16	19	24	

Тайлбар: Мэдээллийн эх үүсвэр

* Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа 2023 он /15-49 насны хүн амд хийгдсэн судалгаа/

** Эрүүл мэндийн үзүүлэлт 2024 он

*** Эрүүл мэндийн статистикийн мэдээлэл, 2024 он

**** Халдварт бус өвчин, осол гэмтэлийн шалтгаан, эрсдэлт хүчин зүйлийн тархалтын үндэсний IY судалгаа 2019 он

--- оОо ---